



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/69/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг, Сайншанд хот)
2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 7052-2734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер:
Утас: 7052-3020 Цахим хаяг: Ц.Лүндэгмаа
Аудитор: Л.Баасандорж
Утас: 9905-5703 Цахим хаяг: baskal88@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Ч.Энхтуяа-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018.12.17-наас 2019.02.20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдрийн 13 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

1.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургууль талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургууль нь уламжлалт ёс заншил, өв соёлоо дээдлэн хүндэлдэг, Зөв Монгол хүнийг төлөвшүүлэн сургадаг улсын шилдэг сургууль болох гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын үйлчилгээ
- Боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлэх
- Суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Үгүй

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургууль нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 1 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Үүсгэсэн эрсдэл нь төсвийн гүйцэтгэлийн зарцуулалттай холбоотой тул Нийт зардлыг үнэ цэнийн суурь болгон сонголоо. -холбоотой юм.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургууль 2018 оны *Нийт зардал* 8,330,994.24 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 8,330.38 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь зардлын дүнд суурилсан эрсдэл үүсгэх ажил гүйлгээнүүд нь уг дүнгээс доош тохиолдолд аливаа шийдвэр гаргалтанд үр нөлөөгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|-----|----------|---------|
| 1 | Зөвлөмж өгсөн | 0 | 0.00 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 1 | 6,760.04 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0.00 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 1 | 6,760.04 | |

1.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1.8.1.1 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

Тайлант онд 6,760.04 мян.төгрөгийн авлагатай, 602.48 төгрөгийн өглөгтэй ажиллаж төсвийг үр ашиггүй удирдан зарцуулсан байна.

Энэ нь үнэн зөв байх, оршин байх, бодитой байх зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 45 дугаар зүйл “Төсвийн хэмнэлт”, 46 дугаар зүйл “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах журам” зэрэг заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тавих, актын төлбөрийг хүү торгуулийн орлогын дансанд 2019 онд батлагдсан төсвөөс төлж барагдуулах, авлага бүхий байгууллагатай холбогдох тооцоог дуусгах, хэрэгжилтийг 2019 оны 3 дугаар сарын 25-нд багтаан гүйцэтгэх

1.8.1.2 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Цалин, НДШ-ийг 1454,70 мян.төгрөгөөр гүйлгэн зарцуулсан, цахилгааны зардлаас 311,0 мян.төгрөгийн бараа материалаарх хөрөнгө, 1,782 мян.төгрөгийн гэрээт ажлын хөлс зарцуулсан байна. Мөн 145.9 мян.төгрөгийн кабель, цахилгааны утас, лент зэргийг тогтмол зардлын төсвөөс худалдан авч тайлагнасан байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой байх зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2015 оны 07 дугаар тушаал "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай", уг тушаалын 2-р хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал”, Сангийн сайдын

2014 оны 55 дугаар тушаал “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” зэрэг эрх зүйн актуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгч, хэрэгжилтийн дараагийн аудитаар үргэлжлүүлэн шалгахаар үлдээлээ.

1.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Цалин хөлсний бүртгэл, тайлагнал
Төсвийн гүйцэтгэлийн тайлагнал

1.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 60 бүлэг хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 761,194.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 732,765.56 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь цалингийн зардал 26,168.80 мян.төгрөгөөр, НДШ-ийн зардал 688.82 мян.төгрөгөөр, тогтмол зардал 1,062.22 мян.төгрөгөөр, хангамж, бараа материал 0.94 мян.төгрөгөөр, нормативт зардал 0.14 мян.төгрөгөөр, бусад үйлчилгээний зардал 0.03 мян.төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 507.8 мян.төгрөгөөр тус тус хэмнэгдсэнээс шалтгаалсан бөгөөд төсвийн хэмнэлтийн хэлбэлзлийн хамгийн гол асуудал нь орон тоо дутуу ажилласнаас цалингийн сан хэмнэгдсэн зэргээс шалтгаалжээ.

1.11 Шилэн дансны мэдээлэл

Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

1.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 95% хувьтай байна.

Өмнөх аудитаар 3 зөвлөмж, 2 зөрчилтэй асуудал хөндөгдсөн ба тайлант хугацаанд үүнээс авлагатай холбоотой асуудал энэ тайлант онд дахин давтагдсан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

1.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 ТӨСВИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

Илрүүлэлт

Тайлант онд 6,760.04 мян.төгрөгийн авлагатай, 602.48 мян.төгрөгийн өглөгтэй ажилласан байна. Эдгээр өглөг, авлага нь цалин хөлс, түүнтэй холбоотой НДШ, ХХОАТ-тай холбоотой үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, 45, 46 дугаар зүйл, заалтууд болон Сангийн сайдын 2017 оны 216 тушаалаар батлагдсан “Төсвийн зардлын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-тай үл нийцэж байна.

Эрсдэл

Тайлант оны батлагдсан төсвөөс ирэх оны зардлыг санхүүжүүлэх, хөрөнгө шамшигдах, төсвийг үр ашиггүй зарцуулах

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 7.7, 6.4.8, 45, 46 дугаар заалтууд, Сангийн сайдын 2017 оны 216 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн зардлын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлж ажиллах
Цалин хөлстэй холбоотой холбогдох тооцооллуудыг үнэн зөв, бодитой гүйцэтгэх, зөрүү үүсгэхгүй байх

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ч.Энхтуяа

Төсвийн захирагчийн хариу

Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдлийн улмаас нийгмийн даатгал болон татварт өглөг үүсэх магадлалтай ба төсвийн тодотгол орохгүй учраас татвар, нийгмийн даатгалын зөрүүтэй суутгалаар үүссэн

Үйлчлүүлэгч хариуг 2019.02.20-нд бичгээр ирүүлсэн болно.

3.2 БАТЛАГДСАН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт

Цалин, НДШ-ийг 1454,70 мян.төгрөгөөр гүйлгэн зарцуулсан, цахилгааны зардлаас 311,0 мян.төгрөгийн бараа материалаарх хөрөнгө, 1,782 мян төгрөгийн гэрээт ажлын хөлс зарцуулсан байна.

Мөн 145.9 мян.төгрөгийн кабель, цахилгааны утас, лент зэргийг тогтмол зардлын төсвөөс худалдан авч тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын Зардлын эдийн засгийн ангиллыг баталсан 07 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэл

Төсөвт байгууллагын хөрөнгө, нэмэлт орлогыг дутуу бүртгэх, ашиг сонирхлын зөрчил үүсэх

Эцэг эхчүүдийн хандиваар бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаагүйгээс хөрөнгөнд тавигдах НББ-ээрх хяналт алдагдах

Зөвлөмж

Сангийн сайдын 2015 оны 07 дугаар тушаал "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай", уг тушаалын 2-р хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал "Тушаалд өөрчлөлт оруулах тухай" зэрэг эрх зүйн актуудыг хэрэгжүүлж ажиллах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаянгийн Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ч.Энхтуяа

Төсвийн захирагчийн хариу

1454.7 мян.төгрөгийн өглөгтэй байсан өглөг барагдуул гэсэн албан бичгийн дагуу НДШ-ийн ажил олгогчоос шилжүүлэх боломжгүй байсан учир цалингийн сангаас шилжүүлсэн, мөн зайлшгүй шаардлагатай байсан гэрээт ажлын зардлыг холбогдох зардал хүрэлцэхгүй байсан учир уг зардлаас гаргасан.

Үйлчлүүлэгч хариуг 2019.02.20-нд бичгээр ирүүлсэн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 3-р сарын 25-аас 2019 оны 12 дугаар сарын 25-ны дотор үе шаттайгаар ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ч.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Ц.ЛҮНДЭГМАА

БЭЛТГЭСЭН: АУДИТОР:

Л.БААСАНДОРЖ

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|---|------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>106,039,771.15</u> | <u>94,801,434.94</u> |
| 33 | АВЛАГА | 10,984,534.14 | 6,760,041.43 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 80,984.00 |
| 335 | Бусад авлага | 10,984,534.14 | 6,679,057.43 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 10,984,534.14 | 6,679,057.43 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 95,055,237.01 | 88,041,393.51 |
| 351 | Түүхий эд материал | 27,302,500.00 | 27,293,700.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 27,139,200.00 | 27,139,200.00 |
| 35130 | Эм боох материал | 163,300.00 | 154,500.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 1,047,900.00 | 00.00 |
| 354 | Хангамжийн материал | 66,704,837.01 | 60,747,693.51 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 569,900.00 | 159,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 65,021,115.50 | 59,142,192.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 105,700.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,008,121.51 | 1,446,001.51 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>885,124,127.93</u> | <u>1,646,809,495.63</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 885,124,127.93 | 1,646,809,495.63 |
| 392 | Биет хөрөнгө | 885,124,127.93 | 1,414,585,495.63 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,619,186,460.54 | 1,337,647,161.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -834,301,030.98 | 00.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 16,950,000.00 | 16,950,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -12,947,916.88 | -16,950,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 133,531,213.17 | 133,531,213.17 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -96,987,833.11 | -111,657,913.57 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 90,048,992.25 | 92,400,992.25 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -47,613,193.50 | -56,719,418.78 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 13,172,700.00 | 15,497,700.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -10,793,149.56 | -13,172,700.00 |
| 39217 | Ном | 14,877,886.00 | 17,058,461.56 |
| 393 | Биет бус хөрөнгө | 00.00 | 232,224,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,124,500.00 | 1,124,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,124,500.00 | -1,124,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 232,224,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>991,163,899.08</u> | <u>1,741,610,930.57</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>3,091,107.09</u> | <u>602,478.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 3,091,107.09 | 602,478.00 |
| 413 | Өглөг | 3,091,107.09 | 602,478.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 3,091,107.09 | 602,478.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>988,072,791.99</u> | <u>1,741,008,452.57</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 988,072,791.99 | 1,741,008,452.57 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 534,459,510.80 | 766,683,510.80 |
| 51101 | Өмч: - төрийн | 534,459,510.80 | 766,683,510.80 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -167,685,998.81 | -225,469,646.43 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -167,685,998.81 | -167,685,998.81 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -57,783,647.62 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 621,299,280.00 | 1,199,794,588.20 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>991,163,899.08</u> | <u>1,741,610,930.57</u> |

3.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|----------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 792,838,230.00 | 775,535,595.56 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,976,200.00 | 7,370,875.56 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 6,976,200.00 | 7,354,208.90 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,976,200.00 | 7,354,208.90 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,085,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,976,200.00 | 6,268,708.90 |
| 122 | Тусламжийн орлого | 00.00 | 16,666.66 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 00.00 | 16,666.66 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 785,862,030.00 | 6,970,520.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 778,194,200.00 | 00.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 778,194,200.00 | 00.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 761,194,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,667,830.00 | 6,970,520.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,667,830.00 | 6,970,520.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 939,516,548.40 | 830,994,243.18 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 939,516,548.40 | 830,994,243.18 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 882,450,008.40 | 768,150,105.95 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 397,518,470.30 | 422,894,675.00 |
| 210101 | Үндсэн цалин | 300,541,487.30 | 278,407,217.34 |
| 210102 | Нэмэгдэл | 65,976,983.00 | 101,813,929.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,000,000.00 | 5,332,000.00 |
| 210104 | Урамшуулал | 26,000,000.00 | 37,341,528.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,876,687.17 | 53,027,907.25 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,090,612.09 | 46,463,389.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,241,693.00 | 1,641,129.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,787,559.00 | 1,312,903.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,930,132.00 | 328,225.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,826,691.08 | 3,282,258.87 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 222,160,880.00 | 185,481,144.14 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,256,240.00 | 7,688,684.00 |
| 210302 | Түлш, халаалт | 205,427,743.00 | 162,471,631.14 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,476,897.00 | 15,320,829.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 42,133,999.90 | 9,564,765.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 451,510.00 | 964,540.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,163,840.00 | 1,230,615.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,598,145.50 | 1,996,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 176,890.00 | 22,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 259,500.00 | 239,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,165,111.00 | 5,112,110.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 4,005,438.00 | 00.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 32,313,565.40 | 00.00 |
| 2105 | Нормативт зардал | 26,169,906.00 | 24,737,698.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 125,200.00 | 220,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,082,826.00 | 20,509,585.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,961,880.00 | 4,008,113.50 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 29,290,581.80 | 7,588,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 29,290,581.80 | 7,588,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 500,000.00 | 1,189,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 500,000.00 | 1,189,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 688,000.00 | 1,373,430.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 688,000.00 | 1,373,430.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 120,111,483.23 | 62,292,786.06 |

| | | | |
|--------|---|------------------------|-----------------------|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 108,950.00 | 468,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,787,189.00 | 5,932,770.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 107,215,344.23 | 55,891,516.06 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 57,066,540.00 | 62,844,137.23 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 56,766,540.00 | 34,415,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,917,740.00 | 17,710,800.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 25,648,800.00 | 16,704,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,200,000.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 300,000.00 | 28,428,637.23 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 300,000.00 | 28,428,637.23 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -146,678,318.40 | -55,458,647.62 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 2,611,236.00 | 2,325,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 2,611,236.00 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 2,325,000.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -2,611,236.00 | -2,325,000.00 |
| 5 | НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -149,289,554.40 | -57,783,647.62 |

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 786,106,530.00 | 769,250,220.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 00.00 | 1,085,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 00.00 | 1,085,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 1,085,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,085,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 786,106,530.00 | 768,164,720.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 778,194,200.00 | 00.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 778,194,200.00 | 00.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 761,194,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,912,330.00 | 6,970,520.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,667,830.00 | 6,970,520.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 244,500.00 | 00.00 |
| 2 | НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 785,901,530.00 | 768,678,020.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 785,901,530.00 | 768,678,020.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 727,584,030.00 | 706,881,782.77 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 404,185,100.00 | 416,804,893.30 |
| 210101 | Үндсэн цалин | 307,208,117.00 | 275,049,285.30 |
| 210102 | Нэмэгдэл | 65,976,983.00 | 95,039,458.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,000,000.00 | 4,846,231.00 |
| 210104 | Урамшуулал | 26,000,000.00 | 41,869,919.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 44,399,500.00 | 57,662,990.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,373,773.92 | 40,816,090.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,165,363.00 | 4,211,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,018,864.00 | 3,369,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,552,973.00 | 842,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,288,526.08 | 8,423,400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 199,357,000.00 | 185,345,879.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,500,000.00 | 7,834,584.00 |
| 210302 | Түлш, халаалт | 179,000,000.00 | 162,190,466.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,857,000.00 | 15,320,829.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,726,200.00 | 5,436,835.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 700,000.00 | 783,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,194,000.00 | 944,915.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.00 | 1,591,000.00 |

| | | | |
|--------|---|----------------------|----------------------|
| 210404 | Ном, хэвлэл | 367,000.00 | 329,170.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 282,000.00 | 282,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,183,200.00 | 1,505,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 18,971,500.00 | 23,148,665.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 151,200.00 | 251,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,296,298.00 | 20,947,465.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,524,002.00 | 1,950,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 29,334,000.00 | 9,796,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 29,334,000.00 | 9,296,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 500,000.00 | 1,189,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 500,000.00 | 1,189,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,668,900.00 | 1,807,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,668,900.00 | 1,807,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,441,830.00 | 5,690,320.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 450,000.00 | 748,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,991,830.00 | 4,941,520.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 58,317,500.00 | 61,796,237.23 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 58,017,500.00 | 33,367,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,728,700.00 | 16,662,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 26,088,800.00 | 16,704,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,200,000.00 | 00.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 300,000.00 | 28,428,637.23 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 300,000.00 | 28,428,637.23 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3) | 205,000.00 | 572,200.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 205,000.00 | 572,200.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 205,000.00 | 572,200.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 205,000.00 | 572,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 205,000.00 | 572,200.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -205,000.00 | -572,200.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-------------------------|------------------------|--|
| 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 534,459,510.80 | 621,299,280.00 | -18,633,384.41 | 1,137,125,406.39 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 534,459,510.80 | 621,299,280.00 | -18,633,384.41 | 1,137,125,406.39 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -149,289,554.40 | -149,289,554.40 |
| 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 534,459,510.80 | 621,299,280.00 | -167,685,998.81 | 988,072,791.99 |
| 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 534,459,510.80 | 621,299,280.00 | -167,685,998.81 | 988,072,791.99 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 534,459,510.80 | 621,299,280.00 | -167,685,998.81 | 988,072,791.99 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 578,495,308.20 | 00.00 | 578,495,308.20 |
| Тайлант үеийн үр дүн | 232,224,000.00 | 00.00 | -57,783,647.62 | 174,440,352.38 |
| 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 766,683,510.80 | 1,199,794,588.20 | -225,469,646.43 | 1,741,008,452.57 |

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ЭЗ ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|-------------------|---|------------------------------|------------------|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 761,194,300.00 | 732,765,562.77 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 761,194,300.00 | 732,765,562.77 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 727,318,900.00 | 699,397,962.77 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 440,452,200.00 | 414,283,400.30 |
| 210101 | Үндсэн цалин | 289,342,100.00 | 272,527,792.30 |
| 210102 | Нэмэгдэл | 101,570,500.00 | 95,039,458.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,760,000.00 | 4,846,231.00 |
| 210104 | Урамшуулал | 43,779,600.00 | 41,869,919.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,143,300.00 | 54,454,483.47 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,755,600.00 | 37,607,583.47 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,347,000.00 | 4,211,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,477,500.00 | 3,369,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 869,400.00 | 842,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,693,800.00 | 8,423,400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 186,408,100.00 | 185,345,879.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,879,100.00 | 7,834,584.00 |
| 210302 | Түлш, халаалт | 162,188,000.00 | 162,190,466.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 16,341,000.00 | 15,320,829.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,167,100.00 | 5,166,165.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 784,100.00 | 783,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 945,000.00 | 944,915.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,591,000.00 | 1,591,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 282,000.00 | 282,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,065,000.00 | 1,064,300.00 |
| 2105 | Нормативт зардал | 23,148,800.00 | 23,148,665.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 251,200.00 | 251,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,947,600.00 | 20,947,465.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,950,000.00 | 1,950,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,596,100.00 | 9,596,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 500,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,096,100.00 | 9,096,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,189,000.00 | 1,189,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,189,000.00 | 1,189,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,363,100.00 | 1,363,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,363,100.00 | 1,363,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 485,120.00 | 485,117.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 748,800.00 | 748,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,102,400.00 | 4,102,370.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 338,754,000.00 | 333,676,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 33,875,400.00 | 33,367,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,170,700.00 | 16,662,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,704,700.00 | 16,704,700.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 761,194,300.00 | 761,194,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 761,194,300.00 | 761,194,200.00 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 44.00 | 44.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 23.00 | 23.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 20.00 | 20.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 44.00 | 44.00 |
| 650004 | СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 24.00 | 24.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 20.00 | 20.00 |

